



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитын код: БНА-2021/39/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2021 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цээням:

Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

Агуулга

1.Төрийн аудитын санал дүгнэлт /Эх хувь/	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал.....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.9. Аудитын илрүүлэлт	16
Залруулсан алдаа	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	17
Аудитын зөвлөмж	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	20
4. Менежментийн захидал	20
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021. 02. 25 № 2/174

танай _____-ны № _____-т

Г **АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ** Г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага нь аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан биелэлтийг тооцон ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн;
- Өмнөх оны зөвлөмж, төлбөрийн актыг бүрэн биелүүлээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил давтагдсан;
- Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын аж ахуйн материалын дүн санхүүгийн тайлангаарх үлдэгдлээс 1330.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, ерөнхий нягтлан бодогч тооцоо бодсон акт бодоогүй, тооллогын бүртгэлийг баталгаажуулах тушаалыг байгууллагын удирдлага гараагүй.
- Оны эцэст санхүүгийн тайланд бүртгэлтэй 85279.6 мянган төгрөгийн авлага, 27955.2 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлээгүй.
- Санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй 2019 оны зардлын 20195.5 мянган төгрөгийг 2020 оны төсвөөс олгосон байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэг хүлээнэ”, 20.2.6 дахь “Ерөнхий нягтлан бодогч нь хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын Тохиолдсон байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй

баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	311,680,870.09	555,713,710.47
33	АВЛАГА	139,736,490.09	316,030,780.47
335	Бусад авлага	139,736,490.09	316,030,780.47
3351	Байгууллагаас авах авлага	138,155,978.09	315,207,923.47
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,580,512.00	822,857.00
34	УРЬДЧИЛГАА	1,693,825.00	653,825.00
3471	Урьдчилгаа тооцоо	1,693,825.00	653,825.00
34713	Цалингийн урьдчилгаа	1,693,825.00	653,825.00
35	БАРАА МАТЕРИАЛ	170,250,555.00	239,029,105.00
354	Хангамжийн материал	170,250,555.00	239,029,105.00
35410	Бичиг хэргийн материал	2,761,500.00	1,914,300.00
35420	Аж ахуйн материал	167,478,555.00	233,258,305.00
35430	Сэлбэг хэрэгсэл	10,500.00	3,856,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,234,493,824.44	7,263,742,701.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,234,493,824.44	7,263,742,701.10
391	Газар	493,380.00	493,380.00
392	Биет хөрөнгө	5,609,320,778.14	6,684,186,321.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,457,677,673.57	6,524,843,110.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	-354,232,642.14	-485,081,972.70
39203	Авто-тээврийн хэрэгсэл	636,599,000.00	554,754,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-362,504,458.61	-252,493,583.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	218,057,398.79	261,612,698.79
39206	Хуримтлагдсан элэгдэл	-151,420,016.09	-176,318,549.55
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	297,615,156.09	312,142,079.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-141,881,333.47	-159,681,461.66
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	95,000,000.00
39217	Ном	9,410,000.00	9,410,000.00
393	Биет бус хөрөнгө	624,679,666.30	579,062,999.90
39301	Програм хангамж	96,300,000.00	96,300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-17,933,333.70	-38,550,000.10
39303	Бусад биет бус хөрөнгө	615,228,000.00	549,778,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-68,915,000.00	-28,465,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,546,174,694.53	7,819,456,411.57
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	175,781,363.80	28,671,596.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	175,781,363.80	28,671,596.00
413	Өглөг	175,781,363.80	28,671,596.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	6,115,772.00	1,344,307.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	39,596,337.00	00.00
4136	Бусад өглөг	130,069,254.80	27,327,289.00
41361	Байгууллагад төлөх өглөг	129,827,254.80	25,498,944.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	242,000.00	1,828,345.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,370,393,330.73	7,790,784,815.57
51	Засгийн газрын хувь оролцоо	6,370,393,330.73	7,790,784,815.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,240,774,740.11	1,240,774,740.11
51101	Өмч: - төрийн	1,240,774,740.11	1,240,774,740.11
512	Хуримтлагдсан үр дүн	3,693,516,118.84	5,114,304,306.38
51210	Өмнөх үеийн үр дүн	3,693,516,118.84	3,693,912,821.54
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,420,391,484.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,436,102,471.78	1,435,705,769.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,546,174,694.53	7,819,456,411.57

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,862,650,159.80	6,606,045,863.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,366,847,404.80	1,484,273,412.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,444,146,104.80	1,484,273,412.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,444,146,104.80	1,484,273,412.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,417,974,104.80	177,939,158.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,172,000.00	1,306,334,254.00
121	Хөрөнгийн орлого	1,922,701,300.00	00.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	1,922,701,300.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,495,802,755.00	5,121,772,451.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	328,508,955.00	1,603,552,851.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	328,508,955.00	400,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	1,203,552,851.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,167,293,800.00	3,518,219,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,167,293,800.00	3,518,219,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,188,410,089.76	5,154,153,753.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,188,410,089.76	5,154,153,753.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,936,902,590.96	4,820,957,999.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	889,474,784.00	1,098,284,740.52
210101	Үндсэн цалин	889,474,784.00	1,098,284,740.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,868,791.71	127,958,704.05
210201	Тэтгэврийн даатгал	106,868,791.71	127,958,704.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	273,148,606.00	267,657,152.00
210301	Гэрэл, цахилгаан	15,078,726.00	16,966,443.00
210302	Түлш, халаалт	219,419,276.00	217,809,857.00
210303	Цэвэр, бохир ус	10,141,604.00	11,280,852.00
210304	Байрны түрээс	28,509,000.00	21,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	198,929,540.00	161,283,882.00
210401	Бичиг хэрэг	15,651,070.00	24,646,800.00
210402	Тээвэр, шатахуун	104,955,875.00	85,961,971.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,337,524.00	26,188,356.00
210404	Ном, хэвлэл	36,006,800.00	6,746,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	635,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,438,271.00	17,105,655.00
2105	Нормативт зардал	17,157,045.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,157,045.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	60,041,918.00	27,077,685.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,982,318.00	00.00
210604	Урсгал засвар	54,059,600.00	27,077,685.00
2107	Томилолт, зочны зардал	133,197,671.00	72,085,200.00
210702	Дотоод албан томилолт	64,639,400.00	44,447,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	68,558,271.00	27,637,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,579,370,408.00	1,551,557,417.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,569,808,712.00	1,540,418,900.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,000,000.00	7,415,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,643,076.00	1,512,880.00

**Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	253,000.00
210807	Газрын төлбөр	718,620.00	1,456,807.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	678,713,827.25	1,515,053,218.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	399,615,065.00	1,214,299,403.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,428,300.00	16,360,480.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	261,670,462.25	284,393,335.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,507,498.80	333,195,754.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	122,113,358.00	188,524,261.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,387,669.00	124,964,605.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,297,000.00	50,073,856.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	91,428,689.00	13,485,800.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	129,394,140.80	144,671,493.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	294,914.00	123,503,871.25
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт санхүүжилт	129,099,266.80	21,167,621.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,674,240,070.04	1,451,892,109.82
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	10,534,515.57	31,500,624.98
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	10,534,515.57	31,500,624.98
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-10,534,515.57	-31,500,624.98
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,663,705,554.47	1,420,391,484.84

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,914,149,136.80	5,326,610,834.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,417,227,281.80	70,288,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,417,227,281.80	70,288,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,417,227,281.80	70,288,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,417,227,281.80	70,288,500.00
13	ТУСПАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,496,921,855.00	5,256,322,334.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	328,508,955.00	1,737,515,466.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	328,508,955.00	400,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	1,337,515,466.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,167,293,800.00	3,518,219,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,167,293,800.00	3,518,219,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,119,100.00	587,268.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,119,100.00	587,268.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,914,149,136.80	5,281,160,234.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,914,149,136.80	5,281,160,234.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,661,371,538.00	4,949,348,012.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	879,164,339.00	1,070,119,329.75
210101	Үндсэн цалин	409,685,862.00	502,896,224.40
210102	Нэмэгдэл	153,939,392.00	155,414,125.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,457,000.00	60,084,177.76
210104	Урамшуулал	00.00	51,442,069.20
210105	Гэрээт ажлын хөлс	266,082,085.00	300,282,732.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,031,900.00	149,642,600.00

**Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210201	Тэтгэврийн даатгал	106,031,900.00	149,642,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	266,394,100.00	307,002,398.00
210301	Гэрэл, цахилгаан	15,078,726.00	16,966,443.00
210302	Түлш, халаалт	214,148,130.00	257,155,103.00
210303	Цэвэр, бохир ус	8,658,244.00	11,280,852.00
210304	Байрны түрээс	28,509,000.00	21,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	148,397,877.00	140,619,256.00
210401	Бичиг хэрэг	17,739,970.00	16,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	80,620,735.00	83,458,224.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,498,223.00	21,470,847.00
210404	Ном, хэвлэл	14,530,000.00	6,052,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	540,000.00	635,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,468,949.00	12,803,185.00
2105	Нормативт зардал	4,121,900.00	4,760,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,121,900.00	4,760,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	56,870,140.00	44,735,000.00
210602	Тавилга	10,502,490.00	6,276,000.00
210604	Урсгал засвар	46,367,650.00	38,459,000.00
2107	Томилолт, зочны зардал	131,585,371.00	74,446,750.00
210702	Дотоод албан томилолт	64,639,400.00	44,447,500.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	66,945,971.00	29,999,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,631,025,538.00	1,724,975,162.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,621,463,842.00	1,713,836,645.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,000,000.00	7,415,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,643,076.00	1,512,880.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	253,000.00
210807	Газрын төлбөр	718,620.00	1,456,807.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	437,780,373.00	1,433,047,517.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	417,785,073.00	1,416,334,637.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,995,300.00	16,712,880.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	252,777,598.80	331,812,222.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	123,383,458.00	187,140,729.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,119,100.00	587,268.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,387,669.00	124,964,605.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,297,000.00	50,073,856.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	91,579,689.00	11,515,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	129,394,140.80	144,671,493.05
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	294,914.00	123,503,871.25
213405	Төвлөрүүлэх шилжүүлэг нэмэлт санхүүжилт	129,099,266.80	21,167,621.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	45,450,600.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	45,450,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	45,450,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	45,450,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	45,450,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-45,450,600.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,240,774,740.11	1,436,102,471.78	3,693,516,118.84	6,370,393,330.73
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,240,774,740.11	1,436,102,471.78	3,693,516,118.84	6,370,393,330.73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	396,702.70	396,702.70
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,240,774,740.11	1,436,102,471.78	3,693,912,821.54	6,370,790,033.43
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-396,702.70	00.00	-396,702.70
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,420,391,484.84	1,420,391,484.84
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,240,774,740.11	1,435,705,769.08	5,114,304,306.38	7,790,784,815.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөөр /	
				Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,588,219,600.00	3,465,004,228.75	123,215,371.25	96.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,588,219,600.00	3,465,004,228.75	123,215,371.25	96.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,401,541,200.00	3,278,450,767.75	123,090,432.25	96.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,105,963,900.00	1,070,119,329.75	35,844,570.25	96.76
210101	Үндсэн цалин	421,977,900.00	502,896,224.40	-80,918,324.40	119.18
210102	Нэмэгдэл	149,845,700.00	155,414,125.83	-5,568,425.83	103.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,904,000.00	60,084,177.76	8,819,822.24	87.20
210104	Урамшуулал	77,004,400.00	51,442,069.20	25,562,330.80	66.80
210105	Гэрээт ажлын хөлс	388,231,900.00	300,282,732.56	87,949,167.44	77.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,642,600.00	149,942,600.00	-300,000.00	100.20
210201	Тэтгэврийн даатгал	105,304,100.00	149,642,600.00	-44,338,500.00	142.11
210202	Тэтгэмжийн даатгал	11,084,600.00	00.00	11,084,600.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,867,700.00	00.00	8,867,700.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,216,900.00	00.00	2,216,900.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,169,300.00	00.00	22,169,300.00	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	348,196,500.00	307,002,398.00	41,194,102.00	88.17
210301	Гэрэл, цахилгаан	17,100,000.00	16,966,443.00	133,557.00	99.22
210302	Түлш, халаалт	298,196,500.00	257,155,103.00	41,041,397.00	86.24
210303	Цэвэр, бохир ус	11,300,000.00	11,280,852.00	19,148.00	99.83
210304	Байрны түрээс	21,600,000.00	21,600,000.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	141,303,200.00	140,619,256.00	683,944.00	99.52
210401	Бичиг хэрэг	16,200,000.00	16,200,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	83,500,000.00	83,458,224.00	41,776.00	99.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,900,000.00	21,470,847.00	429,153.00	98.04
210404	Ном, хэвлэл	6,100,000.00	6,052,000.00	48,000.00	99.21

**Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	635,000.00	165,000.00	79.38
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,803,200.00	12,803,185.00	15.00	100.00
2105	Нормативт зардал	4,760,000.00	4,760,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,760,000.00	4,760,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,680,000.00	56,680,000.00	5,000,000.00	91.89
210602	Тавилга	15,031,000.00	10,031,000.00	5,000,000.00	66.74
210604	Урсгал засвар	46,649,000.00	46,649,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	74,760,400.00	74,446,750.00	313,650.00	99.58
210702	Дотоод албан томилолт	44,760,400.00	44,447,500.00	312,900.00	99.30
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	30,000,000.00	29,999,250.00	750.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,368,800.00	32,500,217.00	3,868,583.00	89.36
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,767,300.00	21,361,700.00	3,405,600.00	86.25
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	7,500,000.00	7,415,830.00	84,170.00	98.88
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,800,000.00	1,512,880.00	287,120.00	84.05
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	300,000.00	253,000.00	47,000.00	84.33
210807	Газрын төлбөр	1,501,500.00	1,456,807.00	44,693.00	97.02
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1478865800.00	1442680217.00	36,185,583.00	97.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,462,145,800.00	1,425,967,337.00	36,178,463.00	97.53
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	16,720,000.00	16,712,880.00	7,120.00	99.96
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	186678400.00	186553461.00	124,939.00	99.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	186,678,400.00	186,553,461.00	124,939.00	99.93
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	125,024,500.00	124,964,605.00	59,895.00	99.95
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	50,073,900.00	50,073,856.00	44.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,580,000.00	11,515,000.00	65,000.00	99.44
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,588,219,600.00	3,464,004,228.75	124,215,371.25	96.54
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,518,219,600.00	3,394,715,728.75	123,503,871.25	96.49
132001	Орон нутгийн төсвөөс	3,518,219,600.00	3,394,715,728.75	123,503,871.25	96.49
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	70,000,000.00	70,288,500.00	-288,500.00	100.41
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000,000.00	70,288,500.00	-288,500.00	100.41
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	96.00	96.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	11.00	11.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	38.00	38.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	34.00	34.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	96.00	96.00	0.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	38.00	38.00	0.00	100.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	04.00	04.00	0.00	100.00

**Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

650008	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	17.00	0.00	100.00
650010	Гэрээт ажилтан	34.00	34.00	0.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	03.00	03.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /				
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,716,347,845.00	-1,716,347,845.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,716,347,845.00	-1,716,347,845.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,716,347,845.00	-1,716,347,845.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,716,347,845.00	-1,716,347,845.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,716,347,845.00	-1,716,347,845.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,737,515,466.80	-1,737,515,466.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,737,515,466.80	-1,737,515,466.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	400,000,000.00	-400,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	1,337,515,466.80	-1,337,515,466.80

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга М.Өнөржаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны цахим хуудаст мэдээллийг цаг тухайд нь байршуулах зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 20-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн ЗДТГ 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2021.01.25-ний өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Тус байгууллага “Би биш бид. Баянхонгор аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааг КОВИД-19 халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулахад энэ түрүүнд иргэдэд чиглэсэн түргэн шуурхай үйлчилгээг эрхэмлэсэн

санхүүгийн болоод хүний нөөцийн хувьд манлайлагч байгууллага болно” гэсэн эрхэм зорилго тавьж ажилласан байна.

Байгууллагын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хуулиудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын төсвийн захирагчаар 2020.01.01-2020.09.11-ний хооронд Ц.Дашцэрэн, 2020.09.24-2020.12.31-ний хооронд М.Өнөржаргал, ерөнхий нягтлан бодогчоор 2020.01.01-2020.07.16-ний хооронд Т.Энхдалай, 2020.07.06-2020.12.31-ний хооронд Э.Амарбаясгалан, туслах нягтлан бодогчоор 2020.01.01-2020.07.05-ний хооронд Э.Амарбаясгалан, 2020.08.20-2020.12.31-ний хооронд Б.Ичинхорлоо, нярваар З.Мягмардаш нар ажилласан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн ЗДТГ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон аудитор хийж гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн ЗДТГ нь “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Acolous санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг үр дүнгийн тайлангийн зардал 1.0 тэрбум төгрөгөөс дээш тул 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 03 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 1 хувиар буюу 29515.9 мянган төгрөгөөр тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын 1 хувиар буюу 52232.4 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд тооцсон материаллаг байдлын түвшнээс 22716.5 мянган төгрөгөөр их байгаа нь 4 дүгээр улиралд зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Гүйцэтгэлийн явцад шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2888965.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 390778.9 мянган төгрөгөөр буюу 11.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мян.төг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	311,680.9	555,713.7	244,032.8
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	139,736.5	316,030.8	176,294.3
Урьдчилгаа	1,693.8	653.8	(1,040.0)
Бараа материал	170,250.6	239,029.1	68,778.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,234,493.8	7,263,742.7	1,029,248.9
Үндсэн хөрөнгө	7,331,380.6	8,404,333.3	1,072,952.7
Хуримтлагдсан элэгдэл	(1,096,886.8)	(1,140,590.6)	(43,703.8)
Нийт хөрөнгө	6,546,174.7	7,819,456.4	1,273,281.7
Өр төлбөр	175,781.4	28,671.6	(147,109.8)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,370,393.3	7,790,784.8	1,420,391.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,546,174.7	7,819,456.4	1,273,281.7

Эх сурвалж: Байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 2 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд 141430.3 мянган төгрөгийн авлагатай байснаас 129099.2 мянган төгрөг нь НҮБ-ийн Хүүхдийн сангийн буцаасан санхүүжилтийн авлага байсан ба өмнөх оны авлагаас 138717.1 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, 2713.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, тайлант онд 327012.3 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, оны эцэст 329725.6 мянган төгрөгийн авлагатай гарчээ.

Оны эцэст үлдэгдлээр байгаа авлагаас 200000.0 мянган төгрөг нь аймгийн Засаг даргын захирамжаар 5 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, Улаанбаатар хот руу мах тээвэрлэх тээврийн зардал, 19680.0 мянган төгрөг нь онцгой байдлын нөхцөл байдлаас шалтгаалж аймгийн хэмжээнд маскийн нөөц бүрдүүлэх зорилгоор аймаг болон 20 сумын эмийн сангуудад олгосон маскийн үнэ, 102217.0 мянган төгрөг нь аймгийн Засаг даргын

2020.10.22-ний А/683, 2020.11.05-ний өдрийн А/737 дугаар захирамжуудыг үндэслэн "Эн эн си си" ХХК-тай байгуулсан ногоон тэжээлийн авлага байгаа нь дийлэнх хувийг эзэлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 239029.1 мянган төгрөг болж өмнөх оноос 68778.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 22719.3 мянган төгрөгийн бараа материал хандиваар авсан, төсвийн хөрөнгөөр худалдан авсан аж ахуйн материал, сэлбэг хэрэгслийг тайлант онд олгоогүйтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оны эцэст 7331380.6 мянган төгрөг байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 61527.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 1283614.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй авч, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 73, 107, 108 дугаар тогтоолуудаар үндсэн хөрөнгө акталж, 8404333.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүн 1420391.4 мянган төгрөгөөр нэмэгдэж 5114304.3 мянган төгрөг болсон байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын улсын төсвөөс авах санхүүжилт өмнөх оноос 1365925.8 мянган төгрөгөөр буюу 61.4 хувиар өссөн нь Засаг даргын нөөц хөрөнгө өмнөх оноос 1063329.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг өмнөх онд 55000.0 мянган төгрөгөөр төлөвлөж байсныг 2020 онд 15000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 70000.0 мянган төгрөгөөр баталжээ.

Нийт зардал өмнөх онд 2222274.8 мянган төгрөг байсан бол тайлант оны зардал өмнөх оноос 1242729.3 мянган төгрөгөөр буюу 55.9 хувиар өсөж, 3465004.2 мянган төгрөг гарсан нь өмнөх оны үзүүлэлтээс бараа үйлчилгээний зардлыг 1178440.2 мянга, урсгал шилжүүлгийг 64289.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн 396.7 мянган төгрөгөөр өөрчлөгдсөн нь дахин үнэлгээтэй хөрөнгө акталсантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд ЗДТГ-ын зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3393858.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 442262.7 мянган төгрөгөөр бууруулж, 2951596.1 мянган төгрөгийг баталсан ба төсвийг 10 дугаар сард 347623.5 мянга, 11 дүгээр сард 11000.0 мянга, 12 дугаар сард 278000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зардлыг 3588219.6 мянган төгрөгөөр баталжээ.

Анхны батлагдсан төсөв	2020 оны 12 сард зохицуулалт хийсэн төсөв
3393858.8	3588219.6

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 3518219.6 мянга, өөрийн орлогоор 70000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгаас олгохоор батлагдсан санхүүжилтийг бүрэн авч, архивын орлогоор 124318.3 мянган төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 54318.3 мянган төгрөгөөр давуулснаас 54029.8 мянган төгрөгийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн

дансанд шилжүүлж, оны эцэст 288.5 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлж, 70000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд орсон давсан орлогоос 43511.7 мянган төгрөгийг байгууллагын хурлаар хэлэлцсэний дагуу зарцуулж, үлдэх 10518.0 мянган төгрөгийг оны эцэст төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Сангийн яамны Э-тайлангаас татагдсан төсвийн хэлбэлзэлд бараа үйлчилгээний бусад зардлын төлөвлөгөө батлагдсан төсвийн хуваариас 4760.4 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа ба энэ талаар аймгийн СТСХ-ийн төсвийн мэргэжилтэн Б.Бат-Ирээдүйгийн өгсөн тайлбарт “Сангийн яамны Freebalance программд алдаа өгч төсөв татагдахгүй байгаа улмаас үүссэн, программын баазыг Канад улс руу явуулж засуулж байгаа, программ хэвийн болж төсөв татагдах үед зөрүү арилна” гэсэн байгаа тул төсвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлагдсан хуваарийг үндэслэн аудитлав.

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэл /хөтөлбөрөөр/

/мян.төг/

	ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
II	80101-ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ				
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,063,067.70	1,971,979.91	91,087.79	95.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,063,067.70	1,971,979.91	91,087.79	95.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,105,963.90	1,070,119.33	35,844.57	96.76
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,642.60	149,642.60	00.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	348,196.50	307,002.40	41,194.10	88.17
2104	Хангамж, бараа материалын зардал	141,303.20	140,619.26	683.94	99.52
2105	Нормативт зардал	4,760.00	4,760.00	00.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,680.00	56,680.00	5,000.00	91.89
2107	Томилолт, зочны зардал	70,000.00	74,446.75	-4,446.75	106.35
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,601.50	11,138.52	462.98	96.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	169,920.00	157,571.06	12,348.94	92.73
	80205-МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДАЛ				
	2.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,000.00	4,000.00	00.00	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,000.00	4,000.00	00.00	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,000.00	4,000.00	00.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,000.00	4,000.00	00.00	100.00
	3.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	186,678.40	186,553.46	124.94	99.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	186,678.40	186,553.46	124.94	99.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	186,678.40	186,553.46	124.94	99.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	186,678.40	186,553.46	124.94	99.93
	81102-ОРОН НУТГИЙН НӨӨЦ ХӨРӨНГӨ				
	5.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,304,073.50	1,275,476.46	28,597.04	97.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,304,073.50	1,275,476.46	28,597.04	97.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,304,073.50	1,275,476.46	28,597.04	97.81
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,304,073.50	1,275,476.46	28,597.04	97.81
	4. 81518-МӨРИЙН ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН ЗАРДАЛ				
	6.НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	30,400.00	26,994.40	3,405.60	183.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,400.00	26,994.40	3,405.60	183.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,400.00	26,994.40	3,405.60	183.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,767.30	17,361.70	3,405.60	83.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,632.70	9,632.70	00.00	100.00

Эх сурвалж: Э-тайлангаас татагдсан төсвийн хэлбэл, төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 1893506.2 мянган төгрөгийн орлого оруулсан ба гүйцэтгэлээр 1872338.5 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст 21167.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 3. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Шилэн дансанд байршуулах мэдээллээс мэдээллийг хугацаанд нь байршуулж, мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.
1	Бүтэн жил	11	11	7	4	151
2	Хагас жил	4	4	4	0	101
3	Улирал бүр	1	4	3	1	267261.6
4	Сар бүр	3	36	24	12	50
5	Тухай бүр	8	96	63	33	
Нийт		27	151	101	50	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЗДТГ-ын шилэн данс

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитыг ахлах аудитор Б.Должмаа хийж гүйцэтгэн, аудитаар нийт 268057.4 мянган төгрөгийн 18 алдаа зөрчил илрүүлсэнд 16437.3 мянган төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 75338.3 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага өгч, 47182.6 мянган төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгч, 129099.2 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд залруулсан байна.

Өмнөх аудитаар өмнөх оны авлага, өглөгийг барагдуулах, төсвийн хөрөнгөөр согтууруулах ундаа, ахуйн хэрэгцээний бараа худалдан авч байгааг зогсоох, Сангийн сайдын 2017 оны 216 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг мөрдөж давсан орлогыг хамт олны хурлаар хэлэлцүүлж, журмын дагуу зарцуулж байх зэрэг зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 477712.9 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар шийдвэрлэв.

Залруулсан алдаа

Аудитаар өглөгтэй холбоотой 13041.0 мянган төгрөгийн дараах залруулгыг залруулан баталгаажуулав. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын 2020.10.22-ний А/683, 2020.11.05-ний өдрийн А/737 дугаар захирамжуудыг үндэслэн Улаанбаатар хотын "Эн эн си си" ХХК-тай аймгийн Засаг дарга 2020.11.04-ний өдөр 105798.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, тайлант онд 3581.0

мянган төгрөг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд орсон байхад санхүүгийн тайланд тус аж ахуйн нэгжээс авах авлагыг 13041.0 мянган төгрөгөөр дутуу буюу 89176.0 мянган төгрөгөөр тусгасан байна.

Шийдвэрлэсэн нь: "Эн эн си си" ХХК-аас авах авлагыг 13041.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 464671.9 мянган төгрөгийн 20 залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 10166.8 мянган төгрөгийн 6 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 96905.0 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 357600.0 мянган төгрөгийн 9 зөрчилд зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

1. Тавилга эд хогшил худалдан авах зардлаас 2020.02.21-ний өдөр "Айети Юнипикэйшн" ХХК-д 9455.0 мянган төгрөгийг шилжүүлж, тоног төхөөрөмж авснаас 3100.0 мянган төгрөгийн АЗ форматын каноныг тайлант онд орлогод авалгүй, санхүүгийн тайланд авлагаар тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тоног төхөөрөмжийн үнэ 3100.0 мянган төгрөгийг "Айети Юнипикэйшн" ХХК-аар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Аймгийн Засаг даргын 2020.05.27-ний өдрийн А/360 дугаар тушаалаар улсын аварга малчны шагналд 1353.0 мянган төгрөгийн бэлгийн багцыг иргэн Б.Мөнхзаяагаас худалдан авах гүйлгээг санхүү, төрийн сангийн мэргэжилтэн 2 удаа гүйлгээг хийсэн байхад тухайн иргэнээр илүү шилжүүлсэн мөнгийг буцаан төлүүлээгүй атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "Нягтлан бодох бүртгэлд ...бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг.. заавал бүртгэнэ" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Иргэн Б.Мөнхзаяагаар нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Аймгийн ЗДТГ-ын даргаар ажиллаж байсан Ц.Дашцэрэнд Батлан хамгаалах яамны "Хүндэт жуух бичиг"-ийн дагалдах мөнгөн шагналд 200.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Батлан хамгаалах сайдын 2013 оны А/142 дугаар тушаалаар баталсан "Батлан хамгаалах яамны шагнаж урамшуулах журам"-ын 3.5 дахь "Батлан хамгаалах яамны "Хүндэт жуух бичиг"-ээр батлан хамгаалах салбарт идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж цэргийн албыг 10-аас дээш жил тасралтгүй хааж /ажиллаж байгаа/ цэргийн албан хаагч, ажилтан нарыг шагнаж, 30000 төгрөгийг дагалдуулан олгоно" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Иргэн Ц.Дашцэрэнгээр илүү олгосон 153.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

4. Аймгийн Засаг даргын 2020.02.06-ний өдрийн А/73 дугаар захирамжаар зохион байгуулсан "Оюунлаг гэр бүл" тэмцээний зардлаас хувь хүний орлогын албан татварт 260.0 мянган төгрөгийг суутган тооцсон атлаа төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь "Албан татвар төлөгчийнүйл ажиллагааны орлогод албан татвар ногдоно",

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хувь хүний орлогын албан татварыг мэдээлж, байгууллагын 2021 оны төсвөөс 260,0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5. Аймгийн ЗДТГ-ын дарга М.Өнөржаргал нь байгууллагын албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгох А/308 дугаар тушаалыг 2020.12.14-ний өдөр гаргахдаа өөртөө болон аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч нарт үр дүнгийн урамшуулал олгох тушаалыг гаргаж, 3650.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.3 дахь “Энэхүү журмын 2.1-д заасан нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдаар 3650.3 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

6. Аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Дашцэрэн, “Өндөр буянт хонгор” ХХК-тай 2018.05.14-ний өдөр байгуулсан орон сууц захиалан бариулах гэрээнд “Аймгийн ЗДТГ-ын газар дээр баригдаж буй 5 давхар орон сууцны 1 дүгээр давхарт 45 м2-аас багагүй байрыг аймгийн ЗДТГ-ын нэр дээр шилжүүлэн өгөх, мөн ЗДТГ-ын нэр бүхий 3 албан хаагчдад 1м2 талбайн үнийг 1050.0 мянган төгрөгөөр борлуулах” гэж заасан ба аймгийн Засаг даргын 2018.06.19-ний өдрийн А/468 дугаар захирамжаар аймгийн ЗДТГ-ын Нийгмийн даатгалын урд хэсэгт байрлах агуулах, аж ахуйн зориулалттай 1185 м2 газрын зориулалтыг төрийн нийтийн албан хаагчийн орон сууцны зориулалттай болгох захирамж гаргасан ба аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.07.31-ний 53 дугаар тогтоолоор 1000 м2 талбай газрыг “Өндөр буянт хонгор” ХХК-д шилжүүлэх шийдвэр гарсан байна. Хоёр талын гэрээнд байгуулсан 1 давхрын 1 өрөө байрыг аймгийн ЗДТГ авч, төсвийн хөрөнгөөс 2020 онд 535.2 мянган төгрөгийг зарцуулж, тохижилт хийлгэж, 455.9 мянган төгрөгийн угаалгын машин авч өгсөн, тус байгууллагын мэргэжилтэн амьдарч байхад хөрөнгөд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэлд ...бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг.. заавал бүртгэнэ” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгөд бүртгэх албан шаардлагыг өгөв.

7. Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтэн Г.Должинсүрэн ээлжийн амралтаа авч, БНСУ-д явсан ба 2020.03.10-ны өдөр ээлжийн амралтын хугацаа дуусч, ажилдаа эргэн

ороогүй байхад тушаал шийдвэргүйгээр 2020 оны 3, 4 дүгээр сарын цалинд 1650.5 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно”, 49.6.дахь “Цагаар ажилласан ажилтны цалин хөлсийг гүйцэтгэсэн ажлын хэмжээ, ажилласан цагаар нь тооцож тухай бүр олгоно” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Г.Должинсүрэнгээр нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

8. Санхүүгийн тайланд бүртгэлтэй 466688.0 мянган төгрөгийн газрыг санхүүгийн программд 1 м.кв-ийн үнэлгээ, нийт талбайн хэмжээгээр бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэсэн, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ дансны үлдэгдэл СТАУС программд зөрүүтэй татагдсан, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалд бүртгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.15-т “Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

9. Өмнөх оны 2259.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчил давтагдсан. Төсвийг зориулалт бусаар зарцуулж, 408.4 мянган төгрөгийг хиам, талх, гутал өнгөлөгч, согтууруулах ундаа худалдан авч, зоогийн газарт өрөөний цагийн төлбөрийг төлөхөд зарцуулсан нь аймгийн Засаг даргын захирамжаар зохион байгуулж байгаа “Архинаас салья” уриатай аянтай нийцэхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ”, аймгийн Засаг даргын 2020.01.02-ний өдрийн А/01 дугаар “Аймгийн хэмжээнд архидан согтуурахтай тэмцэх аян зарлах тухай” захирамжийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн зориулалт бус зарцуулалтыг холбогдох албан хаагчдаар төлүүлж, зөрчил гаргасан албан хаагч болон ерөнхий нягтлан бодогчид сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээ авах албан шаардлагыг хүргүүлэв.

10. Аймгийн Засаг даргын 2020.10.22-ний А/683, 2020.11.05-ний өдрийн А/737 дугаар захирамжуудыг үндэслэн Улаанбаатар хотын “Эн эн си си” ХХК-тай байгуулсан гэрээнд заасны дагуу тус аж ахуйн нэгжээс тарьж ургуулсан 37.1 тонн буюу 16991.0 мянган төгрөгийн ногоон тэжээлийг авч, 2021 онд 58.8 тонн буюу 50421.0 мянган төгрөгийн тэжээлийн үрийг буцаан авсан бөгөөд гэрээнд заасны дагуу тэжээлийг бүрэн тарьж хүлээлгэн өгөөгүй тул 38385.2 мянган төгрөгийг тус аж ахуйн нэгжээр төлүүлэх арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Иргэний тухай хуулийн 222 дугаар зүйлийн 222.1.1 дэх “..Үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол ...үүрэг гүйцэтгэгч хугацаа хэтрүүлсэн гэж үзнэ”, “ 222.7 дахь “Үүрэг гүйцэтгэгч хугацаа хэтрүүлснээс учирсан хохирлыг арилгуулахаар үүрэг

гүйцэтгүүлэгч шаардах эрхтэй”, 227 дугаар зүйлийн 227.1 дэх “Гэрээний нэг тал үүргээ зөрчсөн бол нөгөө тал нь гэрээнээс татгалзсантай холбогдон учирсан хохирлыг арилгуулахаар шаардах эрхтэй” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрд учирсан хохирлыг барагдуулж, тэжээлийг бүрэн тариулах эсвэл ургуулаагүй тэжээлийн үрийн зардлыг нөхөн төлүүлэхээр албан шаардлага хүргүүлэв.

11. Аймгийн Засаг даргын А/157 дугаар захирамжаар "Айети Юнипикэшн" ХХК-аас 8602.0 мянган төгрөгийн өртөг бүхий 4 ширхэг Dell маркын суурин компьютер, Samsung M2020 маркын принтерийг засаг даргын нөөц хөрөнгөөс худалдан авч, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлсэн байхад санхүүгийн тайланд орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгүүдийг орлогод авах албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, үндсэн хөрөнгийн элэгдлийг зөв тайлагнах, авлага, өглөгийн тооцоог баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдэл болон төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах нийт 9 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аудитын цаг хугацаа богино, аймгийн ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэгтгэгдэж байгаа үйл ажиллагааны цар хүрээ их, мөнгөн дүн өндөр байгаагаас гүйлгээний тоо их тул аудитаар ЗДТГ-ын үндсэн дансаар дамжсан байгууллагын үйл ажиллагаа, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлын дүн 3588219.6 мянган төгрөгийн зарцуулалтыг шалгасан ба байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан 1872338.5 мянган төгрөгийг балансын дараа үзэхээр төлөвлөж аудитыг гүйцэтгэлээ.

Аймгийн Засаг даргын захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс худалдан авч байгаа хөрөнгийг бусад байгууллага хөрөнгөд бүртгэж авч байгаад тавих хяналт сул, мэргэжилтнүүд зохион байгуулсан арга хэмжээний зардлын гүйцэтгэлийг илтгэсэн тайланг бичиж байгууллагын санхүүд хүлээлгэн өгдөггүй, санхүүгийн тайланд тусгаагүй өглөгийг барагдуулсан зэргийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

1.1. **Илрүүлэлт:** Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.09.14-ний өдрийн 188 дугаар тогтоолоор "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-ын 200000.0 мянган төгрөгийн өртөг бүхий 8 ширхэг техник хэрэгслийг аймгийн ЗДТГ-т шилжүүлсэн байгаа нь цаашид ЗДТГ-ын үйл ажиллагаанд ашиглагдахгүй, эдгээр техник хэрэгслийг худалдан авахад үүссэн өр төлбөрийг ямар байгууллагад бүртгэхийг тогтоолд тусгаагүй байна.

- 1.2. **Эрсдэл:** Эрх бүхий байгууллагын шийдвэрийг биелүүлээгүй байх.
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Үйл ажиллагааны онцлогт уялдуулан "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-аас шилжүүлэн авсан техник хэрэгслийг Сум дундын Ойн ангид шилжүүлж, өглөгийн асуудлыг эрх бүхий албан тушаалтнаар гаргуулах арга хэмжээ авах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.
2. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ
 - 2.1. **Илрүүлэлт:** Оны эцэст санхүүгийн тайланд бүртгэлтэй 85279.6 мянган төгрөгийн авлага, 27955.2 мянган төгрөгийн өглөгийг харилцагч байгууллага, аж ахуйн нэгжтэй тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэг хүлээнэ" гэснийг зөрчсөн байна.
 - 2.2. **Эрсдэл:** Санхүүгийн тайлан дахь авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байх.
 - 2.3. **Өгсөн зөвлөмж:** Харилцагч байгууллага, аж ахуйн нэгжтэй Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу тооцоо нийлж, барагдуулах арга хэмжээг авч ажиллах.
 - 2.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.
3. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ
 - 3.1. **Илрүүлэлт:** Байгууллагын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй томилолтын зардалд 3366.0 мянга, "Сумын хөгжил" хөтөлбөрийн судалгааны ажилд 829.5 мянга, "Баянхонгор аймгийн Мал сүргийг хулгайн гэмт халдлагаас хамгаалах монголын нийгэмлэгийн аймгийн зөвлөгөө"-ний зардалд 16000.0 мянга, нийт 20195.5 мянган төгрөгийг 2020 оны төсвөөс олгосон байна.
 - 3.2. **Эрсдэл:** Тайлант жилийн зардлаас өмнөх оны өглөгөөр тусгаагүй зардлыг олгох
 - 3.3. **Өгсөн зөвлөмж:** Тухайн жилийн зардлыг тайлант оны санхүүгийн тайланд бүрэн тусгах, авлага, өглөггүй ажиллах.
 - 3.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.
4. БАЛАНСЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ
 - 4.1. **Илрүүлэлт:** Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн аж ахуйн материалын тайлангаарх үлдэгдлээс 1330.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, ерөнхий нягтлан бодогч эд хөрөнгийн тооллогын тооцоо бодсон акт үйлдээгүй, байгууллагын дарга тооллогын бүртгэлийг тушаалаар баталгаажуулаагүй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь "Ерөнхий нягтлан бодогч нь хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах үүрэг хүлээнэ" гэснийг зөрчсөн байна.
 - 4.2. **Эрсдэл:** Хөрөнгийн тооллогын тооцоог бодоогүй байх.

4.3. **Өгсөн зөвлөмж:** Хөрөнгийн тооллогод үндэслэн ерөнхий нягтлан нягтлан бодогч тооцоо бодож, тооллогын үр дүнг байгууллагын даргын тушаалаар албажуулж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах.

4.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

5. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

5.1. **Илрүүлэлт:** Үндсэн хөрөнгөд 2016, 2020 онд орлогод авсан 19690.0 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглагдах жилийг хасах нэгээр оруулснаас үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал дутуу илэрхийлэгдсэн.

5.2. **Эрсдэл:** Үндсэн хөрөнгөд элэгдэл бодогдоогүй байх.

5.3. **Өгсөн зөвлөмж:** Санхүүгийн программд үндсэн хөрөнгийн ашиглагдах жилийг зөв оруулж, санхүүгийн тайланд тайлант жилийн элэгдлийн зардал зөв илэрхийлэх.

5.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

6. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

6.1. **Илрүүлэлт:** Аймгийн Засаг даргын захирамжаар 121 хүнд аймгийн тэргүүний ажилтны тэмдгийг олгосон судалгааг хүний нөөц, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн гаргасан байхад нярвын тайлангаар 307 ширхэг, ерөнхий дэвтрээр 347 ширхэг тэмдэг зарлагдаж, 1649.8 мянган төгрөгийн зөрүү гарсан нь аймгийн Засаг даргын захирамжийг хариуцсан мэргэжилтэн бүрэн гараагүй, нярвын гаргасан тайлангаарх зарлагыг санхүүгийн программд зөрүүтэй оруулсантай холбоотой байна.

6.2. **Эрсдэл:** Анхан шатны баримтыг үндэслэн бараа материалыг олгоогүй байх.

6.3. **Өгсөн зөвлөмж:** Тушаал шийдвэрийг тухай бүрд нь гаргаагүй албан тушаалтанд хариуцлага тооцож, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөтлөлтөд тавих хяналтыг сайжруулан, няавын үлдэгдлийг тухай бүр нь тулгалт хийж баталгаажуулж байх.

6.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

7. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

7.1. **Илрүүлэлт:** Сургалт, зөвлөгөөний зардлын төсвийг урьдчилан гаргадаггүй, тушаалыг зардлын гүйцэтгэлээр дараа нь гаргадаг, санхүүгийн баримтад үйл ажиллагааны тайлан, холбогдох баримт материалыг бүрэн өгдөггүй зөрчил нийтлэг байна.

7.2. **Эрсдэл:** Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байх.

7.3. **Өгсөн зөвлөмж:** Арга хэмжээний зардлын төсвийг урьдчилан бэлтгэж хянуулж хэвших, төсөвт багтаан зардлыг төсвийг хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулж, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг санхүүгийн баримтын хамт тухай бүр нь нягтлан бодогчид хүлээлгэн өгч байх.

7.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

8. ЗАРДЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ



- 8.1. **Илрүүлэлт:** Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс элсэлтийн ерөнхий шалгалтад сурагчдаа амжилттай бэлтгэсэн багш нарыг 1500.0 мянган төгрөгөөр шагнахаар аймгийн Засаг дарга А/640 захирамжийг гаргасан байхад тус зардлыг байгууллагын төсвөөс гаргасан, аймгийн Засаг даргын захирамжаар нөөц хөрөнгөөс авч өгсөн хөрөнгө, материалыг бусад байгууллагууд бүртгэж авч байгаа эсэхэд тавих хяналт хангалтгүй байна.
- 8.2. **Эрсдэл:** Хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, бараа материал, үндсэн хөрөнгийг орлогод бүртгэхгүй байх.
- 8.3. **Өгсөн зөвлөмж:** Засаг даргын нөөц хөрөнгөөс олгож байгаа хөрөнгийг орлогод авсан тухай баримтыг шийдвэрийн хамт бусад байгууллагуудаас авч, санхүүгийн баримтад хавсаргах.
- 8.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

9. ТӨСВИЙН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

- 9.1. **Илрүүлэлт:** Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих 151 мэдээллээс 101 мэдээллийг хугацаанд оруулж, 267261.6 мянган төгрөгийн 50 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба үндсэн данснаас 5.0 сая төгрөгөөс дээш дүнгээр гүйлгээ хийгдсэн 5527604.9 мянган төгрөгийн 130 гүйлгээнээс 1450006.8 мянган төгрөгийн 33 гүйлгээг мэдээлээгүй байна.
- 9.2. **Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо бүрдүүлэхгүй байх.
- 9.3. **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, худалдан авалт, үйлчилгээний төлбөрийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах.
- 9.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг холбогдох нотлох баримтын хамт төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА
Огноо: 2021.02.25

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН
МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.25

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.25

5. ХАВСРАЛТ: АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо: 2021.02.25	Аудитын нэр: Баянхонгор аймгийн ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: БНА-2021/39/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Аймгийн ЗДТГ-ын дарга, аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч нарт эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр үр дүнгийн урамшуулал олгосон.	3650.3	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
2	Аймгийн СТСХ-ийн мэргэжилтэнд ажиллаагүй байх хугацаанд тушаал шийдвэргүйгээр 2 сарын цалин олгосон.	1650.6	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
3	"Айети Юнипикэйшн" ХХК-д 2020 оны 02 дугаар сард тоног төхөөрөмжийн үнийг шилжүүлж, 3100.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг аваагүй.	3100.0	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
4	Иргэн М.Мөнхзаяад бараа материалын үнэнд 1353.0 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн атлаа буцаан төлүүлээгүй, тайланд авлагаар тусгаагүй.	1353.0	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
5	Бараа материалын үнээс хувь хүний орлогын албан татварт 260.0 мянган төгрөгийг суутгасан атлаа төсөвт төвлөрүүлээгүй.	260.0	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
6	Аймгийн ЗДТГ-ын даргаар ажиллаж байсан Ц.Дашцэрэнд батлан хамгаалах яамны жуух бичгийн дагалдах мөнгөн шагналд 153.0 мянган төгрөгийг илүү олгосон.	153.0	Төлбөрийн акт тогтоох	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
7	"Өндөр буянт хонгор" ХХК-тай 2018.05.14-ний өдөр байгуулсан орон сууц захиалан бариулах гэрээний дагуу авсан 1 ерөө орон сууцыг орлогод бүртгээгүй.	47250.0	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
8	"Эн эн си си" ХХК аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан ажлыг бүрэн гүйцэтгээгүй.	38385.2	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан

**Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

9	Өмнөх оны авлагыг барагдуулаагүй, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, төсвийг зориулалт бусаар зарцуулж, 408.4 мянган төгрөгийг хиам, талх, гутал өнгөлөгч, согтууруулах ундаа худалдан авч, зоогийн газарт өрөөний цагийн төлбөрийг төлөхөд зарцуулж, зөрчлийг давтан гаргасан.	2667.8	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
10	Санхүүгийн тайланд бүртгэлтэй 466688.0 мянган төгрөгийн газрыг 1 м.кв-ийн үнэлгээ, нийт талбайн хэмжээгээр бүртгээгүй, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг бараа материалд бүртгэсэн байна.	0	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
11	Аймгийн Засаг даргын А/157 дугаар захирамжаар 8602.0 мянган төгрөгийн өртөг бүхий 4 ширхэг Dell маркын суурин компьютер, Samsung M2020 маркын принтерийг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст авч өгсөн байхад санхүүгийн тайланд орлогоор бүртгээгүй.	8602.0	Албан шаардлага өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
12	Оны эцэст санхүүгийн тайланд бүртгэлтэй 85279.6 мянган төгрөгийн авлага, 27955.2 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлээгүй.	133234.8	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
13	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.09.14-ний өдрийн 188 дугаар тогтоолоор "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-ын 200000.0 мянган төгрөгийн өртөг бүхий 8 ширхэг техник хэрэгслийг аймгийн ЗДТГ-т шилжүүлсэн байгаа нь цаашид ЗДТГ-ын үйл ажиллагаанд ашиглагдахгүй, эдгээр техник хэрэгслийг худалдан авахад үүссэн өр төлбөрийг ямар байгууллагад бүртгэхийг тогтоолд тусгаагүй.	200000.0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
14	Санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй 2019 оны зардлын 20195.5 мянган төгрөгийг 2020 оны төсвөөс төлсөн.	20195.5	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
15	Аймгийн Засаг даргын захирамжаар 121 хүнд аймгийн тэргүүний ажилтны тэмдгийг олгосон байхад нярвын тайлангаар 307 ширхэг, ерөнхий дэвтрээр 347 ширхэг тэмдэг зарлагдсан байгаа ба Засаг даргын захирамжийн хавсралтыг хариуцсан мэргэжилтэн бүрэн гараагүй.	1649.8	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
16	Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн аж ахуйн материалын тайлангаарх үлдэгдлээс 1330.0 мянган төгрөгөөр зөрүүтэй, ерөнхий нягтлан бодогч эд хөрөнгийн тооллогын тооцоо бодсон акт үйлдээгүй, байгууллагын дарга тооллогын бүртгэлийг тушаалаар баталгаажуулаагүй.	1330.0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
17	Үндсэн хөрөнгөд 2016, 2020 онд орлогод авсан 19690.0 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглагдах жилийг хасах нэгээр оруулснаас үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал дутуу илэрхийлэгдсэн.	19690.0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан

**Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

18	Сургалт, зөвлөгөөний зардлын төсвийг урьдчилан гаргадаггүй, тушаалыг зардлын гүйцэтгэлээр дараа нь гаргадаг, санхүүгийн баримтад үйл ажиллагааны тайлан, холбогдох баримт материалыг бүрэн өгдөггүй зөрчил нийтлэг илэрсэн.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
19	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргах 1500.0 мянган төгрөгийн зардлыг байгууллагын төсвөөс гаргасан, аймгийн Засаг даргын захирамжаар засаг даргын нөөц хөрөнгөөс байгууллагуудад авч өгсөн хөрөнгийг бүртгэж авч байгаа эсэхэд тавих хяналт хангалтгүй.	1500.0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
20	Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оруулбал зохих 151 мэдээллээс 101 мэдээллийг хугацаанд оруулж, 267261.6 мянган төгрөгийн 50 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 5 сая төгрөгөөс дээш дүнтэй 1450006.8 мянган төгрөгийн 33 гүйлгээг шилэн дансанд мэдээлээгүй орхигдуулсан.	0	Зөвлөмж өгөх	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
21	"Эн эн си си" ХХК-тай аймгийн Засаг дарга 2020.11.04-ний өдөр 105798.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, тайлант онд 3581.0 мянган төгрөг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд орсон байхад санхүүгийн тайланд тус аж ахуйн нэгжээс авах авлагыг 13041.0 мянган төгрөгөөр дутуу буюу 89176.0 мянган төгрөгөөр тусгасан байна.	13041.0	Санхүүгийн тайланд залруулах	Төсвийн захирагч, нягтлан бодогч	М.Өнөржаргал, Э.Амарбаясгалан
ДҮН		477712.9			

---oOo---